

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 25-ны өдөр

№ 19/61

Улаанбаатар хот

Охин компани байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.8, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.5, 80.6 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.8 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.1, 9.6.5, 9.6.23, 9.10 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан ЛэндМН ББСБ ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани (цаашид “Охин компани” гэх) байгуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Шинээр байгуулах Охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,000,000 (нэг сая) төгрөг бөгөөд нэг бүрийн 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 10,000 (арван мянган) ширхэг гаргасан энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.

3. Охин компани нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үйл ажиллагааг Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх бөгөөд тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсч Монголбанкинд хандахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг хүртэл нэмэгдүүлсүгэй.

4. Охин компани нь “мэдээлэл, технологийн үйл ажиллагаа” эрхлэх бөгөөд Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр үйл ажиллагааны чиглэл нэмэгдүүлэхийг дурдсугай.

5. Охин компанийн Хувь нийлүүлсэн хөрөнгийг энэхүү тогтоолын 2, 3-т заасан хэмжээнд мөнгөн болон биет бус хөрөнгө хэлбэрээр оруулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.

6. ЛэндМН ББСБ ХК-ийг төлөөлөн Охин компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх буюу Охин компанийг үүсгэн байгуулах, бүртгүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр, тогтоол гаргах, дүрмийг батлах, бүртгүүлэх, үүсгэн байгуулагдаж, бүртгүүлсний дараа тус компанийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.

7. Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомж, Компанийн дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

8. Охин компанийг үүсгэн байгуулсны дараа Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ болон шаардлагатай бусад зөвшөөрөл авах хүсэлтийг Монголбанкинд гаргах, зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой шийдвэр, үйл

ажиллагаагаа Төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

ГИШҮҮД:

.....

..... /В.БАЯРСАЙХАН/

.....

..... /О.БОЛДБААТАР/

..... /Ч.НОМИН/

.....

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

.....

..... /С.БОРГИЛ/

.....

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

.....

..... /Н.ЦЭВЭГМИД/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 25-ны өдөр

№ 19/62

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.5, 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1, 89.1.3 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.20, 9.10 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Анд системс” ХХК болон “Монгол телевиз” ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр 19/290 дугаартай Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсантай холбогдуулан “The voice of Mongolia” нэвтрүүлгийн дундуур ЛэндМН ББСБ ХК-ийн сурталчилгаа, мэдээллийг хүргэх, түүнтэй холбоотой “Анд Системс” ХХК-тэй хэлцэл хийх, нэвтрүүлгийг ивээн тэтгэх зардлын зарим хэсгийг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатарт)-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолд заасан хүрээнд нэвтрүүлгийн дундуур байрших “ЛэндМН ББСБ” ХК-ийн сурталчилгааны төлөвлөгөө, мөнгөн дүнг “Анд Системс” ХХК-тай тохиролцон, тогтоох, төлбөрийг холбогдох дансанд шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.


ТУЗ-ИЙН ГИШҮҮД:




/С.БОРГИЛ/



/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



/Н.ЦЭВЭГМИД/



/С.ЭНХ-АМГАЛАН/



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 25-ны өдөр

№ 19/63

Улаанбаатар хот

**Чанаргүй болон муу активыг
зээлийн эрсдэлийн сангаас
хорогдуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 80.6 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3.6 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, “Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ын 3.4, 4.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэж, гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн Гүйцэтгэх удирдлагаас гаргасан саналыг үндэслэн 266,408,994 (хоёр зуун жаран зургаан сая дөрвөн зуун найман мянга есөн зуун ерөн дөрөв) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу зээл, тэдгээрт тооцогдсон 15,611,800 (арван таван сая зургаан зуун арван нэгэн мянга найман зуу) төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийн авлагын төлбөрийг Зээлийн эрсдэлээс хамгаалах сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2019 оны 12 дугаар сарын 30-ны дотор хийх эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
2. Зээлийн эрсдэлээс хамгаалах сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, эрх зүйн акт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

